



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
III УЛИРЛЫН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2019.10.08

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ТЗДТБХЗГ-ын 2019 оны III улирлын үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, СЗХ-наас гарсан шийдвэрийн биелэлт, Нийслэлийн засаг даргатай байгуулсан Санамж бичгийн биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 11 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **80.0%**-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ТЗДТБХЗГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
79	42	22	9	5	1	77.0%

ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ нь 2019 онд 79 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 79 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 42 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 22 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 9 арга хэмжээ, 0%-ийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа болоогүй 1 арга хэмжээ буюу хэрэгжилт дунджаар 77.0%-тай байна. Бүрэн хэрэгжээгүй 36 арга хэмжээнээс 28 нь хэрэгжүүлэх хугацаа хэтэрсэн байна.

Хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээ:

1/ 1.2.4. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж гарах дүрэм, журмын төслүүд боловсруулах /3 улирал 5 журам боловсруулсан байна/

Биелэлт: Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг ЗГ-т өргөн барьсан бөгөөд төслөө зарим нэр томъёоны өөрчлөлтийг сайжруулахаар татаж авсан. Хууль батлагдсаны дараа дүрэм, журмууд шинэчлэгдэнэ. 0%

2/ 1.1.17. Салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааны үр өгөөжийг дээшлүүлэх, концессын гэрээгээр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах /1-4 улирал Төслүүдийн хэрэгжилт 10-аас дээш хувиар сайжирсан байна/

Биелэлт: Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын Концесс эзэмшигчийн зүгээс барилгын ажлыг эхлүүлэх хугацаа сунгах хүсэлт ирүүлсний дагуу Үндэсний хөгжлийн газарт хүсэлтийг уламжлаад байна. Тус чиглэлийн чиг шинэчлэх ажлын хэсэгт ЭХЯ, БОАЖЯ-тай хамтран байгуулагдаж газар дээр нь ажиллаж зарим асуудлыг шийдвэрлэх, төрийн байгууллага салбар хоорондын уялдааг хангах зорилготой ажиллахаар төлөвлөөд байна.

Засгийн газрын 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар концессын зүйлийн жагсаалтад орсон “Ар богдын төмөр зам” ХХК-иас санаачилсан “Богдхан төмөр зам” төслийг хүчингүй болгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Богдхан төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд хийгдэх бөгөөд сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг ханган Ажлын даалгавар боловсруулж байна. 30%

3/ 1.3.7. Хөдлөх бүрэлдэхүүний үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх /3 улирал Шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна/

Биелэлт: Хөдлөх бүрэлдэхүүний үйлдвэр байгуулах төслийг ХХААХҮ-ын яамны “Үйлдвэржилт 21:100”, үндэсний 2018-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт оруулж, санхүүжилтийн дэмжлэг авахаар 2018.03.12-ны өдрийн 08/1060 албан бичгийн хавсралтаар төслийн хураангуйг хүргүүлэв. Хөдлөх бүрэлдэхүүний үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр жил бүрийн Улсын төсөвт суулгах саналыг БТГ-т хүргүүлсэн.

Мөн БНСУ-ын буцалтгүй тусламжид хамрагдуулж, санхүүжилтийн холбогдох эх үүсвэрийг босгох зорилгоор төслийн танилцуулгыг 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 02/4266 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

“Ачааны вагоны үйлдвэр байгуулах” төслийг Сангийн яамны сайт дээр тавьсан. “Ачааны вагон угсрах үйлдвэр”-ийн ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Зам тээврийн хөгжлийн Дэд сайд, МТЗ ТӨХК-ийн мэргэжилтэнүүдтэй 5 дугаар сарын 29-ны өдөр уулзалт зохион байгуулж Дэд сайдаас МТЗ ТӨХК-д тус ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг өгсөн.

Санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Польш Улсаас хэрэгжүүлэх буцалтгүй тусламжаар хийгдэх төсөл, Азийн Хөгжлийн Банкны болон “Korea international Cooperation Agency” төслүүдэд хамруулахаар санал хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр ирээгүй байна. 30%

4/ 2.1.3 Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэх /2-4 улирал Барилгын ажлын 80% гүйцэтгэсэн байна/

Биелэлт: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэхээр ЗТХС-ын 2019 оны 90 дүгээр тушаалаар УУХҮЯ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр, 04 дүгээр сарын 03-ны өдөр тус тус танилцуулж 8, 15 дугаар тэмдэглэлүүд гарсан. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэхээр ЗТХС-ын 2019 оны 185 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэг тус төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлбэрийг тодорхойлон Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр санал гарган Сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлсэн. Тус асуудлаар ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулан 07 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж 304 дүгээр тогтоол батлагдсан. Тогтоолын

хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг тогтоон баталж ТУЗ-ийг шинэчлэх зэрэг ажлууд хийгдсэн. Төслийн барилгын ажил 10 сард эхлүүлэхээр төлөвлөсөн. 0%

5/ 2.1.7. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 46,2 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх /3 улирал. Шивээхүрэн-Сэхэ барилгын ажил дуусч Нарийнсухайт-Шивээхүрэн барилгын ажил эхэлсэн байна/

Биелэлт: Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан бөгөөд царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоосны дараа барилгын ажлыг эхлүүлнэ. Цариг шийдвэрлэгдээгүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй тухай хөрөнгө оруулагч талаас албан ёсоор мэдэгдээд байна. УИХ-ын 2019 оны Хаврын чуулганаар хэлэлцүүлэх явцад тус төслийн ТЭЗҮ, тооцоо судалгааг дахин нягтлах гэсэн шалтгаанаар Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэл гарч буцаан татсан. “Нарийнсухайт төмөр зам” ХХК-иас барилгын ажил эхлүүлэх чиглэл хүссэн албан бичиг ирүүлсний дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон “Монголын төмөр зам” ХХК-д 2018 оны 232 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар чиглэл хүргүүлсэн. 30%

6/ 2.1.9. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 281 км төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төсөл боловсруулах /3 улирал. ТЭЗҮ боловсруулсан байна. Техникийн зураг төсөл 50% боловсруулна/

Биелэлт: Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанд Зүүнбаян-Ханги чиглэл болон Богдхан төмөр замын төслийн талаар танилцуулга оруулсан. Тус өдрийн 18 дугаар хурлын тэмдэглэл гарсан. Тус хуралдааны тэмдэглэлийг үндэслэн төмөр замын төслийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Зүүнбаян-Ханги” төмөр замын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл болон холбогдох тооцоо, судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 186 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг тооцоо, судалгааг эхлүүлэн ажиллаж байна. 30%

7/ 2.1.14. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чигийн солбицолд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх /2 улирал. Төмөр замын чигийг Засгийн газраар хэлэлцүүлсэн байна/

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 282 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Булган аймгийн Бугат суманд 2019.07.02-05ны хооронд ажиллаж, “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын төслийг Хужирын голын хөндийгөөр зэрэгцүүлэн явуулах боломжийг судалж, батлагдсан чигийн дагуу 47 км газарт Эгийн голын усан цахилгаан станц төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр замын трасстай огтлолцох 6 цэгийг газар дээр нь үзэж Хужирын голын хөндийгөөр уялдуулан явуулах боломжтой гэж үзэн Ажлын хэсгийн 2019.07.16-ны 19/228/07 дугаартай дүгнэлтийг гаргасан.

“Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын Концессын гэрээний хугацаа 2020 оны 4 сард дуусахтай холбогдуулан ҮХГ-аас 2019.08.26-ны өдрийн 01/2255 дугаартай албан бичгээр ажлын хэсэг байгуулах санал ирүүлсэн. Уг саналын дагуу концесс эзэмшигч “Нортерн рэйлвэйс” ХХК-ны захирал н.Ган-Очиртой уулзалт зохион байгуулж Хөвсгөл аймгийн Мөрөн чиглэлээр трассыг өөрчлөх боломжийг судлах, өмнөх шийдвэр, мэдээллийг яамны удирдлагуудад танилцуулах чиглэл өгсөн. 0%

8/ 2.1.15. Эрдэнэт-Овоот чиглэлийн 542 км төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх /3 улирал Барилгын ажил 10%/

Биелэлт: Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чигийн дагууд байрлах Булнайн нуруу, Ханжаргалантыг байгалийн цогцолборт болон нөөц газрын ангилалаар Улсын тусгай хамгаалалтад авсан.

Ханжаргалантын байгалийн цогцолборт газраар дайран гарсан асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 282 дугаар тушаалаар

байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь үзэж 2019.07.16-ны 19/228/07 дугаартай Хужирын голын хөндийгөөр зэрэгцүүлэн явуулах боломжтой дүгнэлтийг гаргасан. Булнайн нуруугаар дайран өнгөрөх чигийг өөрчлөх шаардлага үүссэн. 0%

9/ 3.2.5. Далбааны эзэн улсын хяналтын үзлэг, шалгалт явуулах журмыг боловсруулж, батлуулах /3 улирал Журмын төслийг хянан хэлэлцүүлж батлуулсан байна/

Биелэлт: Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан журам тул хуулийн төсөл батлагдсны дараа журмыг батлуулна.

Холбогдох журмын төслийг боловсруулсан. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэр гарсан. УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад хуулийн төсөл орсон бөгөөд хурлаар хэлэлцүүлж батлахтай зэрэгцүүлэн холбогдох журмыг батлуулна. 30%

10/ 3.2.6. Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагыг томилох, тэдгээрийн ажлын гүйцэтгэлийг дүгнэх, дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааг хянан зохицуулах журмыг боловсруулж, батлуулах /2 улирал Журмын төслийг хянан хэлэлцүүлж батлуулсан байна/

Биелэлт: Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан журам тул хуулийн төсөл батлагдсны дараа журмыг батлуулна.

Холбогдох журмын төслийг боловсруулсан. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэр гарсан. УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад хуулийн төсөл орсон бөгөөд хурлаар хэлэлцүүлж батлахтай зэрэгцүүлэн холбогдох журмыг батлуулна. 30%

11/ 3.1.2. Олон улсын Далайн байгууллагаас хийсэн Аудитын зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах /1-4 улирал Төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хэрэгжсэн байна/

Биелэлт: Олон улсын Далайн байгууллагаас хийсэн Аудитын зөвлөмжийн дагуу төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хийгдэж байна. Жилийн эцсээр төлөвлөгөөний биелэлтийг ОУДБ-д хүргүүлнэ. 30%

12/ 3.3.1. БНХАУ-ын Жинжоу боомтын Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг идэвхижүүлэх /3 улирал Монгол Улсын ачаа барааг Жинжоу боомтоор дамжуулан тээвэрлэх үйл ажиллагааг эхлүүлсэн байна/

Биелэлт: БНХАУ-ын Жинжоу боомтын Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг идэвхижүүлэх, Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх талаар судалгааны ажил, тооцоолол хийгдэж байна. 0%

13/ 4.2.1. “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах /1-3 улирал Журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна/

Биелэлт: Журмын төсөл боловсруулагдсан бөгөөд Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа журмын төслийг батлуулна. 30%

Хэрэгжүүлэх хугацаа хэтэрсэн 70%-ийн хэрэгжилттэй арга хэмжээ:

1/ 1.1.1. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах /2 улирал Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна/

2/ 1.1.3. “Тяньжин-Монголын тээвэр логистикийн төв” төслийн ТЭЗҮ-ийг батлуулах /3 улирал “Тяньжин-Монголын тээвэр логистикийн төв” төслийн ТЭЗҮ-ийг батлуулсан байна/

3/ 1.1.13. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн ТЭЗҮ боловсруулах санхүүжилтийг шийдвэрлэх /3 улирал Санхүүжилтийг шийдвэрлэсэн байна/

4/ 1.2.3. “Илчит тэрэг. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг батлуулах /2 улирал Стандартын төслийг батлуулсан байна/

5/ 1.3.3. “УБТЗ” ХНН-ийн төмөр замын их засварын ажил гүйцэтгэх /3 улирал Төмөр замын их засвар 50 км хийгдсэн байна/

6/ 1.3.4. Зорчигч тээврийн үйлчилгээнд төмөр зам, автотээврийн хосолсон орчин үеийн менежмент нэвтрүүлэх /3 улирал Төмөр зам, автотээвэрээр зорчих нэгдсэн тасалбар болон захиалгын гар утасны аппликэйшнтэй болсон байна/

7/ 1.3.10. Үндэсний ажил мэргэжлийн ангилалд Төмөр замын салбарын мэргэжлийн тодорхойлолтыг шинэчлэх, холбогдох ажлыг үргэлжлүүлэх /3 улирал Төмөр замын салбарын мэргэжлийн тодорхойлолтыг шинэчилж дууссан байна/

8/ 2.1.4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 208,5 км-ээс хил хүрэх чигийг тогтоох /4 улирал ТЭЗҮ шинэчилж, төмөр замын чигийг тогтоосон байна/

9/ 2.1.5. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын газрын маргаантай 5 цэгийг шийдвэрлүүлэх /3 улирал Газрын маргааныг шийдсэн байна/

10/ 2.1.6. Хөөт-Бичигт чиглэлийн 234 км төмөр замын ТЭЗҮ-ийг аж үйлдвэрийн паркттай уялдуулан боловсруулах /2 улирал ТЭЗҮ боловсруулсан байна/

11/ 2.1.8. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг шийдвэрлүүлэх /2 улирал УИХ-д өргөн барьж хэлэлцүүлсэн байна/

12/ 3.1.3. Монголын хөлөг онгоцны бүртгэлийн чанарыг сайжруулах, өргөжүүлэх /1-3 улирал Далбааны эзэн улсын хяналт тавих нөхцөл бүрдсэн байна/

13/ 3.1.4 ОУДБ-ын “Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай” 1978 оны конвенцийн 2010 оны Манилагийн нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлэх /1-3 улирал Конвенцийн нэмэлт, өөрчлөлтийг батлуулсан байна/

14/ 3.1.6. Усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогын төсөл боловсруулах 2 улирал Төслийг боловсруулсан байна/

15/ 3.2.4. Хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгсэл ISO 12402:2005 стандартын 10 дахь хэсэг (Part 10)-ийг эх хэлнээ хөрвүүлж, батлуулах. /2 улирал Стандартын төслийг боловсруулж батлуулсан байна/

16/ 3.2.7. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх; /1 улирал ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна/

2.2. МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс				Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
	100%	70%	40%	0%		



21	5	5	3	2	6	72,1%
----	---	---	---	---	---	-------

Үнэлэх боломжгүй арга хэмжээ:

1/ 2.108.2. “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах, төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх; /2016-2020 Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувь/

2/ 2.109.1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаас Оюутолгой чиглэлийн салбар төмөр замыг барих; /2019-2020 Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь/

3/ 2.109.2. “Шивээхүрэн-Сэхэ” боомтын төмөр замыг барих; /2017 Барилгын ажлыг дуусгах/

4/ 2.110.1. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, суурь бүтэц барих ажлыг эхлүүлэх; /2016-2020 Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь/

5/ 2.111.4. “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх /2016-2020/

6/ 2.117.4. Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол, дэд бүтцийг хөгжүүлж, аюулгүй, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагааг сайжруулах /2016-2020 Барилгын ажлыг эхлүүлэх/

Хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээ:

1/ 2.108.1. “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замыг барих; /2016-2018 Барилгын ажлыг дуусгах/

Биелэлт: ЗТХС-ын 2019 оны 185 дугаар тушаалаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлбэрийг тодорхойлон ЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх санал гарган Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх санхүүжилт болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг Засгийн газрын 304 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд барилгын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын Ерөнхий төлөвлөгөө гарган ажиллаж байна. 0%

2/ 2.112.1. “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барих ажлыг эхлүүлэх /2016-2020 Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувь/

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар болон “Нортерн рэйлвэйс” ХХК-ийн хооронд байгуулсан Эрдэнэт хот-Овоотын уурхай чиглэлд төмөр замын суурь бүтцийн зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг сунгах асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний хөгжлийн газар болон бусад холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулсан Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 0%

3/ 2.111.3. “Богдхан” төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэх /2017-2020 Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь/

Биелэлт: Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 260 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтын 53² дахь заалт болох “Богдхан төмөр замын төсөл”-ийг /трасс алдаатай/ хүчингүй болгосон. Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад 1 жилийн хугацаатай сунгасан бөгөөд ТЭЗҮ боловсруулах сонгон шалгаруулалт зарлагдсан байна. 40%

4/ 2.113.1 Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах /2017-2020 Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь/

Биелэлт: Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 260 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтын 53² дахь заалт болох “Богдхан төмөр замын төсөл”-ийг хүчингүй болгосон. Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад 1 жилийн хугацаатай сунгаж ТЭЗҮ боловсруулах тендер зарлагдсан. Богдхан төмөр замын ТЭЗҮ-д логистикийн төвийн тооцоо судалгаа хамаарагдана.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 265 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Уг урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн төслийг 2020-2045 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулахаар ҮХГ-ын төсөл хариуцсан ажлын хэсэгт хүргүүлээд байна. 40%

5/ 2.113.3. Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах /Төрөөс логистикийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах 2017-2018/

Биелэлт: Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Монголын логистикийн холбоо” ТББ-тай 2017 оны 267 дугаар гэрээг байгуулсан. Тус холбооноос эхлэл, дунд, эцсийн тайлан ирүүлсэн.

Дотоодын ачаа урсгалыг тодорхойлох хаанаас хаашаа ямар бараа бүтээгдэхүүнүүд тээвэрлэгдэж байгаа, гадаад худалдааны бодлого, бусад салбарын баримталж байгаа бодлогоос хамааран ачааны хэмжээнд өөрчлөлт орох эсэхийг тодруулж, ЗТХ-ийн дэд сайдын 2019.05.13-ны өдрийн 02/2431 тоот албан бичгээр холбогдох яамдуудаас санал аваад байна.

Логистикийн төв байгуулах судалгаа хийж, зураглалыг боловсруулсан “Монгол логистикийн холбоо” ТББ-ын ирүүлсэн тайланд санал авахаар ҮХГ-т хүргүүлсэн. ҮХГ-аас бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Засгийн газраар батлуулах нь зүйтэй гэж үзсэн. ЗГ-т танилцуулахаар хамтарч ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 265 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулан Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 104 дүгээр тушаалаар байгуулагдсан Төрөөс тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг татан буулгасан. Уг ажлын хэсгийн хүрээнд Зам, тээврийн салбарын урт хугацааны нэгдсэн бодлогыг боловсруулах, тээвэр логистикийн бодлогыг уг бодлогод тусгахаар ажиллаж байна. 40%

2.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс				Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
	100%	70%	40%	0%		
5	2	-	1	1	1	60,0%

Үнэлэх боломжгүй арга хэмжээ:

1/ 7.5.1. Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ зураг төслийг боловсруулах /Хэрэгжилтийн явц хувиар 100%/

Биелэлт: Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл нь Монгол-Орос-Хятадын “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн Төмөр замын зүүн коридор байгуулах төсөлд багтсан.

“Монголын төмөр зам” ТӨХК нь БНХАУ-ын “Башинь төмөр зам” ХХК-тай санамж бичиг байгуулж, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Башинь төмөр зам” ХХК-ийн санхүүжилтээр Хятадын Төмөр замын зураг төслийн гуравдугаар хүрээлэнгээр гүйцэтгүүлсэн.

Тус ТЭЗҮ үр ашиг багатай гарсан тул Хөөт орчимд нүүрс боловсруулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэрийн парк байгуулж төмөр замтай уялдуулан цогцоор нь хөгжүүлэх, ачааны эх үүсвэрийг нэмэгдүүлж, ТЭЗҮ-г шинэчлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/188 дугаар тушаалаар Хөөт аж үйлдвэрийн парк төсөл санаачлагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ТЭЗҮ, төсөл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Тус ажлын хэсэгт ЗТХЯ-наас холбогдох мэргэжилтэн орж ажиллаж, 2019.09.16-ны өдөр ажлын хэсгийн эхний хуралдсан.

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ 7.5.3. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх /Хэрэгжилтийн явц хувиар 20%/

Биелэлт: Тус чиглэлийн төмөр замын батлагдсан чиг нь Булнайн нуруу, Тэсийн голын хөндийгөөр 100 гаруй км дайрч байгаа тул хийгдсэн судалгаа, ТЭЗҮ-д өөрчлөлт орох шаардлагын дагуу концесс эзэмшигч судалгааны ажлууд эхлүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газар болон “Нортерн рэйлвэйс” ХХК-ийн хооронд байгуулсан Эрдэнэт хот-Овоотын уурхай чиглэлд төмөр замын суурь бүтцийн зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг сунгах асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний хөгжлийн газар болон бусад холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулсан Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 0%

2/ 7.5.4. “УБТЗ” ХНН-ийн гол замын их засварын ажлыг гүйцэтгэх /Хэрэгжилтийн явц хувиар 50%/

Биелэлт: 2016 онд гол замын 17 км замд их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2017 онд гол замын 50 км замд их засвар хийж дууссан.

2018 онд гол замын 50.1 км замд их засварын ажил хийсэн.

2019 онд 2019 онд 50 км төмөр замд их засварын ажил хийгдэхээр төлөвлөсөн. Их засварын ажлыг 2019 оны 06 дугаар сарын 26 өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд Хойт-Сүхбаатар хоорондын замд 5526,3 пог.м-г хийж гүйцэтгэсэн. Мөн урд чиглэлд 2019 онд 30000 пог.м буюу 30 км их засварын ажил төлөвлөснөөс 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлүүлэн 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар 10,2 км буюу нийт ажлын 30%-ийг хийж гүйцэтгээд байна. 40%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс					Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%				
98	35	32	12	-	16	3	77,2%	

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ УИХ-ын тогтоол. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай 2010.06.24 №32

5. энэ тогтоолын 2 дахь заалтын 4 дэх дэд заалтад заасан чиглэлтэй уялдуулан хөндлөн болон баруун босоо чиглэлд тавих төмөр замын замнал /маршрут/-ыг нарийвчлан тодорхойлж Улсын Их Хуралд танилцуулах;

Биелэлт: "Баруун босоо бүсийн тэнхлэгийн төмөр зам" ХХК баруун босоо чиглэлд барих төмөр замын чигийн судалгаа хийж, координатыг тодорхойлон боловсруулж ирүүлсэн. ҮХГ-т 2017.04.24-ний өдрийн 02/1692 тоот албан бичгээр Баруун бүсийн босоо тэнхлэгийн төмөр замын тухай тайлбар, танилцуулгыг хүргүүлсэн. 2017.08.23-ны өдөр 01/350 тоот албан бичгээр "Арц суурь бургастайн төмөр зам" ХХК-иас "зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах" нөхцөлөөр концессын гэрээ байгуулж ажиллах хүсэлтээ илэрхийлсэн. Арцсуурь боомт-Бургастай боомт чиглэлийн төмөр замын төслийг концессын зураг төсөл боловсруулах, барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаал"-д Засгийн газрын 2017 оны 296 дугаар тогтоолоор нэмэлтээр оруулж шийдвэрлэсэн. Концесс эзэмшигчийг сонгон шалгаруулсны үндсэн дээр концессын гэрээ байгуулсны дараа төмөр замын замнал /маршрут/-ыг нарийвчлан тодорхойлж УИХ-д танилцуулна. 30%

2/ УИХ-ын Байнгын хорооны тогтоол. Хилийн хяналтын байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай 2009.10.21 №13/45/12

1.7 Ашигт малтмалын олборлолт, экспортын хэмжээ үлэмж хэмжээгээр нэмэгдэж байгаа нөхцөл байдал, стратегийн ач холбогдолтой томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа зэргийг харгалзан нэвтрүүлэх хүчин чадал өндөр, шинэ дэвшилтэт технологид суурилсан автозам, төмөр зам барих, тээвэрлэх асуудлыг шийдвэрлэх.

Ачаа болон зорчигчдын хөдөлгөөний урсгалыг төрөлжүүлэн саадгүй нэвтрүүлэх боломжтой олон улсын жишигт нийцсэн хилийн боомтыг барьж байгуулах, түүнийг дагалдсан жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний бизнесийг хөгжүүлж боомт дагасан төвлөрлийг бий болгох

Биелэлт: 30%

3/ ҮАБЗ-ийн зөвлөмж. "УБ метро" төсөл хэрэгжүүлэх тухай 2013.06.10 №24/15

1.Стратегийн ач холбогдол бүхий "УБ метро" төслийг УИХ-аар батлуулж, төслийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар "УБ метро" төслийн бэлтгэл ажлын зураг, төсөв боловсруулах, инженер-геологийн нарийвчилсан судалгаа болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, төслийн зардлыг нарийвчлан тогтоох зэрэг зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг Япон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцүүлж дэмжүүлсэн. Уг төслийн ТЭЗҮ-ийг гурван үе шаттайгаар бүрэн хийж, төслийн баг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, хэлэлцүүлсэн. МУ-ын ЗГ-аас ажлыг гүйцэтгэх төсвийг шийдвэрлээгүй тул энэ ажил зогссон.

Төслийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "Газар доорх төмөр зам буюу Метро"-ны талаарх заалтыг тусгаад байна. 30%

4/ ЗГ-ын тогтоол. Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013.03.02 №71

Төслийн нэгж байгуулж, бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх талаар дараах арга хэмжээ авч ажиллан тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, тухайн төсөл хэрэгжиж байгаа салбарын эрхэлсэн сайд, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай: /Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр "Шинэ төмөр зам" төсөл/

3.4. бүтээн байгуулалтын ажлын нарийвчилсан график, төлөвлөгөө гаргаж, бүтээн байгуулалтын ажлыг гардан зохион байгуулан түүний гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, улмаар ажлыг нь эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Биелэлт: 30%

5/ ЗГ-ын тогтоол. "Богдхан" төмөр зам болон "Улаанбаатар" холимог тээврийн ложистик төвийг барьж байгуулах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2015.03.23 №110

2."Богдхан төмөр зам" болон "Улаанбаатар" холимог тээврийн ложистик төвийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг АХБ-тай эцэслэн тохиролцож, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхийг ЗТ-ийн сайд Н.Төмөрхүү, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт даалгасугай.

Биелэлт: 30%

6/ ЗГ-ын тогтоол. Төсөл хэрэгжүүлэх тухай 2016.12.07 №180

2. Хавсралтад заасан төслийг түлхүүр гардуулах гэрээгээр өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгож, 2017 оны эхний хагас жилд багтаан гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат нарт даалгасугай. /Чойбалсан хотоос Хөөтийн уурхай хүртэл 192 км төмөр зам барих төсөл, Хөөтийн уурхайгаас улсын хилийн Бичигт боомт хүртэл 234 км төмөр зам барих төсөл, Зүүнбаян өртөөнөөс улсын хилийн Ханги боомт хүртэл 281 км төмөр зам барих төсөл, Нарийнсухайтын уурхайгаас улсын хилийн Шивээхүрэн боомт хүртэлх 45.3 км төмөр зам барих төсөл/

Биелэлт: 30%

7/ ЗГ-ын тогтоол. Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах арга хэмжээний тухай 2018.08.01 №232

2. "Нарийнсухайтын төмөр зам" ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой "Шивээхүрэн төмөр зам" ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

Биелэлт: "МАК" ХХК нь "Нарийнсухайтын төмөр зам" ХХК-ийн ТУЗ-ийг байгуулах, гүйцэтгэх удирдлагыг сонгох анхны хуралдааныг 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн гэрээний гол нөхцлүүд дээр санал авахаар төслийг боловсруулж "МАК" ХХК-д хүргүүлсэн. 2018 оны 09 дүгээр сарын 12-ны "МАК" ХХК-с Хувьцаа эзэмшигчдийн гэрээний төсөлд ирүүлсэн саналыг хүлээн авч уг санал дээр ажиллаж байна. "МТЗ" ТӨХК-ийн ТУЗ-ийн хурлаас "МАК" ХХК-тай хэлэлцээр хийх шийдвэр гаргуулахаар санал бэлдэж байна.

Төслийн хөрөнгө оруулалтын асуудлаар Хятадын талын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээрийг эхлүүлсэн. 30%

8/ ЗГ-ын тогтоол. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай 2018.08.08 №242

7. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, барилга-угсралтын ажлын явцыг тухай бүр ЗГ-ын хуралдаанд танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд даалгасугай.

Биелэлт: 30%

9/ ЗГ-ын тогтоол. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицол батлах тухай 2019.05.12 №189

3. Төмөр замын суурь бүтцийн барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай

Биелэлт: Уг тогтоолоор түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн хилийг төмөр замын чигээс 2 тийш тус бүр 20 км-ээр батлуулсан. Дээрх тогтоолоор батлагдсан түгээмэл тархацтай ашигт малтмалын илрэл бүхий талбай нь барилгын ажилд шаардагдах хангалттай нөөцгүйгээс суурь бүтцийн барилгын ажил хэвийн явагдах боломжгүй болсон. Иймд “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хуулийн 3.3, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбайн хилийг төмөр замын чигээс 2 тийш тус бүр 30 км-ээр батлуулах саналыг УУХҮЯамны сайдад хүргүүлэхээр ажиллаж байна. 30%

10/ ЕС-ын захирамж. Ажлын хэсэг байгуулах тухай /Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замыг барьж байгуулах, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг боловсруулах/ 2018.10.26 №175

2. Техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг 2018 онд багтаан боловсруулж, Засгийн газарт танилцуулах;

Биелэлт: Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо судалгааг Хятадын төмөр замын 20-р групп корпораци хийж байна.

Ажлын хэсгээс ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг өгсөн бөгөөд тус даалгаврын дагуу тухай бүр хяналт тавин ажиллаж байна. Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г боловсруулах чиглэлээр ЗТХЯ, “МТЗ” ТӨХК, БНХАУ-ын “Төмөр замын 20 дугаар товчоо групп” компанийн инженер, мэргэжилтнүүд төмөр замын трассуудын дагуу 2018 оны 10 дугаар сарын 21-31-ний өдрүүдэд явж ажилласан. 30%

11/ ЕС-ын захирамж. Ажлын хэсэг байгуулах тухай /Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барьж байгуулах, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг боловсруулах/ 2018.10.26 №176

2. Техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг 2018 онд багтаан боловсруулж, Засгийн газарт танилцуулах;

Биелэлт: 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай ЗТХСайдын 33 тоот тушаал гарсан. Тушаалын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. 30%

12/ ЗГХ-ны тэмдэглэл. Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин Япон улсын хамтын ажиллагааны банкнаас төмөр замын тээврийг шинэчлэн сайжруулахад зориулж авсан хөнгөлөлттэй зээлийн талаар 2019.05.22 №23

XIII.1. Сангийн яам “Улаанбаатар төмөр зам” ХНН-т дамжуулан зээлдүүлэх 2000 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн МОН-П1, МОН-П2 гэрээгээр олгосонтой холбогдуулан үүссэн өрийн асуудлыг зохицуулах талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан уг асуудлаар Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн саналыг эцэслэн шийдвэрлүүлэх, өрийн үлдсэн хэсгийг зохицуулах арга хэмжээг ойрын хугацаанд авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт

Биелэлт: Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дотоод хэрэгцээнд 1998-2015 онд импортолсон дизелийн түлшний онцгой албан татварт төлсөн 73.8 тэрбум төгрөгийг “Японы Олон улсын хамтын ажиллагааны банк”-аас авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс суутган тооцох тухай асуудлыг УИХ-ын Нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Зээлийн өрийн үлдсэн хэсгийг зохицуулах арга хэмжээ авах зорилгоор "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга болон холбогдох материалыг бэлтгэн 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанд танилцуулсан хэдий ч Сангийн сайд дэмжээгүйн улмаас дүрмийн санг нэмэх асуудал дэмжигдээгүй болно. Сангийн яамтай зөвшилцөхөөр ажиллаж байна. 30%

2.5. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
60	34	18	1	-	1	6	88.5%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ ТУЗ-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай 2018.02.27 №32

3."Монгол Саммок Ложистик" компанийн үйл ажиллагааг эрчимжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд даалгасугай. /Далайн захиргааны дарга, ТЗДТБХЗГ-ын төмөр замын эдийн засаг, тариф хариуцсан мэргэжилтэн, ДЗ-ны Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан мэргэжилтэн, оу-ын гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн/

Биелэлт: Хамтарсан компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд Далайн захиргааны дарга 2017 оны 03 дугаар сард БНСУ-д албан томилолтоор ажиллах хугацаандаа "Саммок Шиппинг" ХХК-ийн удирдлагуудтай албан ёсны уулзалт хийсэн. Уулзалтаар хүлээгдээд буй асуудлуудыг яаралтай шийдвэрлэх, компанийн үйл ажиллагааг эхлүүлэх талаар талууд санал нэгдсэн бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 02-р сарын 27-ны өдрийн 32 дугаар тушаал гарсантай холбогдуулан Солонгосын талд мэдээгдээд байгаа ба ТУЗ-ийн анхны хурлыг хийхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Солонгосын талаас одоогоор Солонгосын зах зээлд шаардлагатай байгаа нүүрсний үзүүлэлтүүд, Монголын нүүрсийг тээвэрлэх боломжтой 6 хөлөг онгоцны даацын үзүүлэлтүүд болон Жинжоу боомтоос Инчеон боомт хүртэлх далайн тээврийн үнийн саналыг ирүүлээд байна. Монгол Улсад нүүрс олборлон худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын нүүрсний анализ, дүгнэлтийн сертификатын хуулбарыг авах хүсэлтийг Ашигт малтмал, газрын тосны газрын Нүүрсний судалгааны хэлтэст 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 1/195 тоот албан бичгээр хүргүүлсэн. Албан бичгийн хариуд нийт 32 компанийн нүүрсний чанарын үзүүлэлт бүхий материалыг хүлээн авч, англи хэл дээр орчуулан Солонгосын талд албан и-мэйлээр хүргүүлсэн. Түүнчлэн, "Эрдэнэс Таван Толгой" ХХК-ийн борлуулалтын албатай 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдөр харилцан санал солилцох уулзалт хийсэн. Уулзалтаар нүүрс угаах үйлдвэрийн асуудлыг эхний ээлжинд эцэслэн шийдвэрлэх шаардлагатай байгааг онцолсон. Солонгосын талаас Монголын 32 компанийн нүүрсний чанарын үзүүлэлтийг нягталж үзсэний дагуу олон улсын нүүрсний зах зээлд худалдан авагчдын шаардлагад нийцэх боломжтой гэж үзсэн компаниудын лицензийн дугаарыг ирүүлсний дагуу судалгаа хийгдэж байна. 30%

2.6. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	

23	22	1	-	-	-	-	98,7%
----	----	---	---	---	---	---	-------

2.7. Засгийн газрын хуралдаанаар 2019 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
7	5	2	-	-	-	91,4%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /2019-03-27/
Биелэлт: Төмөр замын тээврийн тухай хуулийн төсөлд ажлын хэсгийн гишүүн хуульчдаас гадна Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Хуульчдын холбооны гишүүд, Улсын Их хурлын Тамгын газрын ахмад ажилтан хуульч Т.Оюунчимэг, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгч, Прокурорын ерөнхий газрын Сургалтын прокурор, хуульч, МУИС-ын ХЗС-ын Хувийн эрх зүйн тэнхмийн багш, хуульч нараас хуулийн төсөлд тусгайлан санал авч, өгсөн саналыг төсөлд тусгаж ажилласан. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр зөвшөөрсөн албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Сангийн яамнаас 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр тус тус авсан. 70%

2/ “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл /2019-08-21/

Биелэлт: Холбогдох журмын төслийг боловсруулж байна. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэр гарсан. УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад хуулийн төсөл орсон бөгөөд хурлаар хэлэлцүүлж батлахтай зэрэгцүүлэн холбогдох журмыг боловсруулан Засгийн газарт танилцуулна. 70%

2.8. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс				хугацаа болоогүй	Шаардлагагүй болсон	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%			
6	2	3	-	-	-	1	82,0%

Хэлэлцүүлэх шаардлагагүй болсон арга хэмжээ:

1/ “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын царигийн асуудлын талаар /3 сар/
Биелэлт: Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэмэлтээр оруулах УИХ-ын тогтоолын төсөл 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын 23 дугаар хуралдааны тэмдэглэлээр дэмжигдэж, Улсын Их Хурлын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 280 км төмөр замыг нэмэлтээр тусгаж баталсан. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг Улсын Их Хурлаар тогтоолгох шаардлагатай. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон.

Хугацаа хоцорч байгаа арга хэмжээ:

1/ Давхар ачилгат чингэлгийн вагоныг төмөр замын тээвэрт нэвтрүүлэх, тооцоо, судалгааны талаар /8 сар/

Биелэлт: “Давхар ачилгат чингэлгийн вагоныг төмөр замын тээвэрт нэвтрүүлэх” төслийг “МТЗ” ТӨХК боловсруулан тус яаманд ирүүлсэн бөгөөд энэ судалгаанд тулгуурлан туршилтыг Улаанбаатар төмөр замын Замын-Үүд өртөөнөөс Толгойт өртөө хооронд давхар ачилгат чингэлгийн оврын хэмжээтэй хяналтын жаазтай вагон 2 удаа аялуулсан.

2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулж хийгдсэн ажлуудаа дүгнэсэн бөгөөд “Давхар ачилгат чингэлгийн вагоныг төмөр замын тээвэрт нэвтрүүлэх” төслийг 2019 оны 09 сарын Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. 70%

2/ “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгын төслийн талаар /8 сар/

Биелэлт: “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ын төслийг боловсруулсан бөгөөд Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа журмын төслийг батлуулах тул түр хүлээгдэж байна. 70%

3/ Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийн талаарх судалгааны талаар /9 сар/

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологи нэвтрүүлэхээр Олон улсын төмөр замын тээврийн салбарт нэвтэрсэн систем, технологийг судалж, судалгааг өргөн хүрээнд хийх зорилтын хүрээнд ажлын хэсгийн тушаал гарсан.

Ажлын хэсэг төлөвлөгөөны дагуу олон улсын төмөр замын тээврийн салбарт нэвтэрсэн системүүдийг судалж, орчуулууд хийж байна.

Тус судалгааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг” төслийн хүрээнд “Төрийн Интерпрайс Архитектур” төсөлтэй уялдуулан хийхээр ажлын хэсгийн ахлагч шийдвэрлэсэн.

Дээрх асуудлыг 10 дугаар сард Сайдын зөвлөлийн хуралдаанд оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 70%

2.9. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс				Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
8	4	3	1	-	-	80.0%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ Тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хийсэн шалгалтын дүнгийн тухай 2017.01.07 №01

5. Тээвэр зуучийн тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар /Р.Мэргэн/-т, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Артур/-т;

Биелэлт: Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооноос тавьж буй саналаар Тээвэр зуучлалын үйл ажиллагаа нь зөвхөн төмөр замаас гадна бусад салбарын үйл ажиллагаатай нягт уялдаатай байдаг тул Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа гэж дангаар ойлгох, журам боловсруулах нь өрөөсгөл тул энэхүү журмаас урьтаж хууль боловсруулж батлуулах шаардлагатай байгааг талаар санал дэвшүүлсэн. Тээвэр зуучийн тухай хуулийн талаар судалгаа хийж ОХУ-ын холбогдох хуулийг судалсан.

Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журмын төслийг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 264 дүгээр тушаалаар батлуулсан тул хэрэв хуулийн төсөл хийгдвэл төмөр замын салбараас оруулах чиглэл бэлэн болсон. 30%

2.10. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй, Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
11	-	4	3	1	3	46.2%

Үнэлээгүй арга хэмжээ:

1/ 3.6. Нарантуул ОУХТөвийн баруун уулзвар болон төмөр зам дээгүүр гүүрэн гарцыг шинээр барих ажлыг эхлүүлэх. /2018 онд барилгын ажлын хөрөнгийг шийдвэрлэн барилгын ажлыг 2018-2020 онд хийж гүйцэтгэх/

Биелэлт: Төсөв батлагдаагүй. /Үнэлээгүй/

2/ 3.7. Сонсголонгийн уулзвар, төмөр зам дээгүүрх гүүрэн гарцын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх.

Биелэлт: Төсөв батлагдаагүй. /Үнэлээгүй/

3/ Нийслэлийн доторх терминалыг хотын баруун, зүүн хэсэгт шилжүүлэн, хотын баруун, зүүн хэсэгт ачааны холимог терминал байгуулах ажлыг эхлүүлэх

Биелэлт: Сайдыг Нийслэлийн Засаг даргатай хамтарсан ажлын хэсэг байгуулахыг хүлээж байна. /Үнэлээгүй/

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

- 1/ 3.9. Төмөр замаар тусгаарлагдсан гудамж, авто замуудыг холбосон нүхэн гарцуудыг шинээр төлөвлөх, зураг төсөл боловсруулах, барих ажлыг эхлүүлэх /Нийт 7 нүхэн гарц барих/ /2018 онд барилгын ажлын хөрөнгийг шийдвэрлэх. 2018-2020 онд барилгын ажлыг хийж гүйцэтгэх/

Биелэлт: Төмөр замаар тусгаарлагдсан Нийслэлийн гудамж, авто замуудыг холбосон нүхэн гарц байгуулахаар “Хөгжлийн хөтөч” төсөл, “УБТЗ” ХНН-тэй хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж долоон байршилд нүхэн гарц байгуулах боломжтой тухай дүгнэлт гарсаж НАЗХГ-т хүргүүлсэн. Үүнд: Нарны зам-Дүнжингаравын авто замыг холбох, Энхтайвны гүүрний баруун талаар, Хүүхдийн парк-Төв цэнгэлдэх хүрээлэн хооронд, Геологийн төв лабораторийн уулварыг ажилчдын гудамжтай холбох, Барс 2-ын баруун талаар урагш нэвт гарахаар тус тус дүгнэлт гарсан.

Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус санамж бичгийн хүрээнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хөрөнгийн эх үүсвэрийг Нийслэлийн 2019 оны төсөвт тусгаж өгөхийг хүсэж 2018 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02/5294 дугаар албан тоот хүргүүлсэн. 0%

2/ 4.2. Хөшигийн хөндийн “Улаанбаатар” логистикийн төвийн газрыг Шинэ хотын ерөнхий төлөвлөгөөнд оруулах, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх. /2018 онд Улаанбаатар хотоос баруун аймгууд руу тээвэрлэгдэх ачааны түгээлтийг нэгдсэн зохион байгуулалтад оруулна. 2019 онд Түгээлтийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 2020 онд Нэгдсэн түгээлтийн систем бий болно/

Биелэлт: Богдхан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр ЗТЯ болон АХБ хооронд 2014 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсны дагуу Зам, тээврийн яам (хуучин нэрээр), Азийн хөгжлийн банк хооронд 2014 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд АХБ-ны техникийн туслалцаагаар Богдхан төмөр замын чигийн судалгааны ажлыг “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй түншлэл гүйцэтгэсэн. Зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017.09.22-ны өдөр ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг ЗГ-ын хуралдаанаар батлуулах шийдвэр гарсан. Зөвлөх компани чигийн судалгааны эцсийн тайланг 2017.11.14-ний өдөр ЗТХЯ-нд хүлээлгэж өгсөн.

АХБ-наас үзүүлж буй техникийн туслалцааны төслийг цаашид үргэлжлүүлэн “Богдхан” төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх саналыг тавиад байна. “Ар богдын зам” ХХК-ийн санаачилгаар “Богдхан” төмөр замын төслийг “зураг төсөл боловсруулах, барих-ашиглах-шилжүүлэх” нөхцөлтэй, сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулах концессыг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмэлтээр тусгасан. Харин “Богдхан” төмөр замын төслийг Улаанбаатар төмөр замын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тул “Ар Богдын зам” ХХК-иас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Богдхан” төмөр замын төслийн концессыг хүчингүй болгох асуудлыг ЗГ-ын хуралдаанаар шийдвэрлүүлэх хүсэлтийг Үндэсний хөгжлийн газарт 2017.11.14-ний 01/4971 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газраас уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэснээр Богдхан төмөр замын чигийг батлуулж, газар олголтыг шийдвэрлэнэ. 30%

3/ 5.5. Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг Улаанбаатар хоттой төмөр замаар холбох, “Богдхан” төмөр замын /170 км/ төслийн хүрээнд төмөр замын Мандал-Багахангай өртөөдийн чиглэлийн замнал зэрэг судалгаа хийх, газар олголтыг шийдвэрлэх; /2019-2020 Газар олголтын асуудлыг шийдвэрлэсэн байна/

Биелэлт: Азийн Хөгжлийн Банкны техникийн туслалцаагаар “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүнтэй түншлэл “УБТЗ” ХНН-ийн Мандал өртөөнөөс Багахангай чиглэлд шинээр барих “Богдхан” төмөр замын чигийн судалгааны ажлыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлсэн. Эцсийн тайланг 2017-11-14-нд ЗТХЯ-нд ирүүлсэн. Чиг одоогоор батлагдаагүй, газар олголт шийдвэрлэх боломжгүй байна.

“Зүүнбаян-Ханги” төмөр замын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл болон холбогдох тооцоо, судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 186 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг тооцоо, судалгааг эхлүүлэн ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны зүгээс тус төслийн ТЭЗҮ, зураг төсөл хийж гүйцэтгэх санхүүжилтийг техникийн туслалцааг үргэлжлүүлэн олгох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн тул Зам, тээврийн яам /хуучнаар/, Азийн хөгжлийн банк хооронд 2014 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулахаар төслийг бэлтгэн ажиллаж байна. 30%

4/ 6.1. Суудлын вагон депогийн зорчигчийн вагоноос ялгарч буй утааг бууруулах чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран ажиллах; /2018 онд 98 зорчигчийн суудлын вагонд утаа бууруулах тоног төхөөрөмж суурилуулна. 2019 онд 150 зорчигчийн суудлын вагонд утаа бууруулах тоног төхөөрөмж суурилуулна/

Биелэлт: Зорчигчийн вагоноос ялгарах хорт утааг багасгах зорилгоор Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн эзэмшлийн 250 ширхэг зорчигчийн вагонд нэмэлт шүүлтүүр суурилуулах ажлыг Япон Улсын “Кожима” корпорацитай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг ажлын хүрээнд “Кожима” корпорацийн мэргэжилтнүүд Монгол Улсад хүрэлцэн ирж, тоног төхөөрөмжийг суурилуулан, туршиж үзсэн. Туршилтын ажил амжилттай болсон бөгөөд Монгол Улсын мэргэжлийн хяналт, онцгой байдал болон бусад холбогдох байгууллагууд аюулгүй байдлын гэрчилгээ олгосон.

Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 04 дүгээр сард Япон Улсад ажиллаж “Кожима” корпораци, “Жайка” корпорацийн төлөөлөлтэй уулзалт хийж, утаагүй вагон төслийг санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх хүсэлт тавьсан. Мөн утаагүй вагоны төслийг хэрэгжүүлэх хүрээнд Зам, тээврийн хөгжлийн Дэд сайд НЗДТГ-ын удирдлагуудтай 09 дүгээр сарын 13-ны өдөр уулзалт хийж, зорчигчийн 10 вагонд тавих утааг бууруулах төхөөрөмж суурьлуулах зардал болох 140 сая төгрөгийг НЗДТГ-аас гаргах шийдвэр гарсан. 30%

2.11. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
7	4	2	-	-	1	90,0%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

- Газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу ЗГҮАХ, 2018 оны Үндсэн чиглэл, сайд, ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгавраас хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг тусган газрын мэргэжилтнүүдэд нэр заан хариуцуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшинг улирлаар хуваан төлөвлөсөн байна.
- Нийт төлөвлөсөн ажлын 10,2% нь жилийн турш, 6,4% нь тухай бүр хийх ажил байгаа бөгөөд I улиралд нийт ажлын 9,3%, II улиралд 24,5%, III улиралд 38,4%, IV улиралд 10,2%-ийг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Өөрөөр хэлбэл I, IV улиралд харьцангуй бага ажил төлөвлөсөн байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- ТЗДТБХЗГ-ын 2019 оны III улирлын үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, СЗХ-наас гарсан шийдвэрийн биелэлт, Нийслэлийн засаг даргатай байгуулсан Санамж бичгийн биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 11 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 80.0%-тай буюу өмнөх улирлаас 3.4%-иар өссөн дүнтэй байна.
- Далай ашиглах тухай болон Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, тэдгээрийг дагалдан гарах журмуудыг батлуулах, Усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогын төсөл боловсруулах, Төрөөс логистикийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах, Тээвэр зуучийн тухай

хуулийн үзэл баримтлалыг боловсруулах зэрэг хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, бодлогын бичиг баримт боловсруулах ажил удаашралтай байна.

- 3) Санхүүжилт, царигийн асуудал шийдэгдээгүй, ТЭЗҮ нь үр ашиггүй гарсан зэрэг шалтгаанаар бүтээн байгуулалтын томоохон төсөл, арга хэмжээнүүд болох ЗГҮАХ-ийн 6 арга хэмжээ, Үндсэн чиглэлийн 1 арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсоныг “үнэлэх боломжгүй” гэж дүгнэсэн.
- 4) Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-т төмөр замын чиглэлээр тусгагдсан 11 арга хэмжээний хэрэгжилт хамгийн бага буюу 46,2%-тай үнэлэгдсэн байна.
- 5) “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 67 арга хэмжээний биелэлт 57,9%-тай буюу “хэрэгжилт хангалтгүй” дүнтэй гарсан байна. Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй, хариуцан хэрэгжүүлэх субъект нь тодорхойгүй байгаа нь хангалтгүй үнэлэгдэхэд нөлөөлсөн байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Далай ашиглах тухай болон Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого, Төрөөс логистикийн талаар баримтлах бодлого, Тээвэр зуучийн тухай хууль зэрэг УИХ, Засгийн газраар батлуулах ажлууд болон эдгээртэй уялдуулан боловсруулахаар хүлээгдэж буй дүрэм, журам боловсруулах, бүтцийн шинэчлэл хийх ажлуудыг түргэвчлэх;
2. Газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /ялангуяа хэрэгжүүлэх хугацаа хоцорч буй 36 арга хэмжээ/ болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн хэрэгжилт удаашралтай байгаа үүрэг даалгаврыг 2019 онд багтаан хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулж, товч тодорхой, бүрэн гүйцэд тайлагнах;
3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2019 онд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тус газраас хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан санхүүжилт шийдэгдээгүй асуудлуудаас бусад арга хэмжээг хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтэд хүргэхэд анхаарах;
4. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа төсөл, арга хэмжээнүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
5. Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-т төмөр замын чиглэлээр тусгагдсан Төмөр замаар тусгаарлагдсан гудамж, авто замуудыг холбосон нүхэн гарцуудыг шинээр төлөвлөх, зураг төсөл боловсруулах, барих, Суудлын вагон депогийн 238 зорчигчийн суудлын

вагонд утаа бууруулах тоног төхөөрөмж суурилуулах зэрэг арга хэмжээг онцгойлон анхаарч, эрчимжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

6. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль болон Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д нийцүүлэн хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хугацаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой заан боловсруулж, ЗТХ-ийн сайдаар батлуулах;

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ТЗДТБХЗГ-ЫН ДАРГА

Б.АРТУР

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.БАЯРМАА



**ЗТХЯ-НЫ ТЗДТБХЗГ-ЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/III улирлын байдлаар/

№	Хяналтанд байх арга хэмжээ	2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/						
				Дундаж хувь	100	70	40	30	0	Хугацаа болоогүй, хүчингүй болсон, үнэлэх боломжгүй
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	79	78	77,0	42	22	-	9	5	1
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	21	15	64,7	5	5	3	-	2	6
3	Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	5	4	60,0	2	-	1	-	1	1
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	98	79	77,2	35	32	-	12	-	19
5	Сайдын тушаалын биелэлт	60	53	88,5	34	18	-	1	-	7
6	ТНБД-ын тушаалын биелэлт	23	23	98,7	22	1	-	-	-	-
7	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт	7	7	91,4	5	2	-	-	-	-
8	СЗХ-аар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт	6	5	82,0	2	3	-	-	-	1
9	СЗХ-аас гарсан шийдвэрийн биелэлт	8	8	80,0	4	3	-	1	-	-
10	Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт	11	8	46,2	-	4	-	3	1	3
11	Ил тод, нээлттэй байдлын үнэлгээ	7	6	90,0	4	2	-	-	-	1
Нийт		325	286	80,0	155	92	4	26	9	39

**ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
2019 ОНЫ III УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:**

Дундаж хувь 80,0%

